


**МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ  
ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ,  
ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН  
ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ  
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаягаар, эсхүл дараах QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.



# МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА (2024 ОНЫ ЭХНИЙ 7 САРЫН ГҮЙЦЭТГЭЛ)

## ГАДААД ХУДАЛДАА (2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр)



### Нэг. Гадаад худалдааны үзүүлэлт

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт:** 2024 оны эхний 7 сарын дүнгээр гадаад худалдааны нийт бараа эргэлт **15,677.0** сая ам.доллар болж 2023 оны мөн үеэс **1,954.7** сая ам.доллар буюу **14.2** хувиар өсчээ. Экспортын дүн импортын дүнгээс **2,854.7** сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс эерэг гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 7 сар		Өөрчлөлт	
	2023	2024	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	13,722.3	15,677.0	1,954.7	14.2
-Экспорт	8,698.5	9,265.9	567.4	6.5
-Импорт	5,023.8	6,411.1	1,387.3	27.6
Тэнцэл	3,674.7	2,854.7	-820.0	-22.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Гадаад худалдааны тэнцэл:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл **2,854.7** сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс **820.0** сая ам.доллараар буурахад импорт **1,387.3** сая ам.доллараар өсч экспортыг давсан нь нөлөөлсөн байна.

**Экспорт:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр **9,265.9** сая ам.доллар болж, 2023 оны мөн үетэй харьцуулахад **567.1** сая ам.доллар буюу **6.5** хувиар өссөн байна.

**Импорт:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр импорт **6,411.1** сая ам.долларт хүрч, 2023 оны мөн үетэй харьцуулахад **1,387.4** сая ам.доллар буюу **27.6** хувиар өссөн байна.

### Хоёр. Гол нэр төрлийн экспортын бүтээгдэхүүн

Нийт экспортын **88.3** хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, **11.7** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт **8,178.9** сая ам.доллар болж, өмнөх оноос 626.8

сая ам.доллар буюу 8.3 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт **1,087.0** сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 59.4 сая ам.доллар буюу 5.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 7 сар		Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	7,552.1	8,178.9	626.8	8.3	88.3
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	1,146.4	1,087.0	-59.4	-5.2	11.7
Нийт экспорт	8,698.5	9,265.9	567.4	6.5	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

### ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ БОЛОН ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 57.9 хувийг нүүрс, 18.9 хувийг зэсийн баяжмал, 5.1 хувийг боловсруулаагүй алт, 3.8 хувийг төмрийн

хүдэр, 1.1 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Хүснэгт 3. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	эхний 7 сар		Өмнөх оны мөн үеэс	
		2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	891.3	927.6	36.3	4.1
Нүүрс	сая.тн	34.0	46.1	12.1	35.6
Төмрийн хүдэр	сая.тн	3.1	4.3	1.2	37.1
Цайрын баяжмал	мян.тн	107.4	74.1	-33.3	-31.0
Алт	тн	6.3	6.6	0.3	4.3
Боловсруулаагүй нефть	сая.баррель	2.8	2.4	-0.4	-14.8
Катодын зэс	тн	6.8	7.5	0.7	10.4
Жоншны баяжмал	мян.тн	524.1	713.1	189.0	36.1
Адууны мах	мян.тн	15.2	5.7	-9.5	-62.6
Өлөн гэдэс	тн	251.7	396.3	144.6	57.4

Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	10.0	22.3	12.3	123.4
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	271.0	185.8	-85.2	-31.5
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	37.4	22.3	-15.1	-40.3
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	41.0	35.7	-5.3	-13.0
Самнасан ноолуур	тн	417.1	320.4	-96.7	-23.2
Бохир ноолуур	тн	3,638.0	3,701.2	63.2	1.7
Хонины самнаагүй ноос	мян.тн	6.1	2.4	-3.7	-60.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

#### Хүснэгт 4. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Барааны төрөл	эхний 7 сар		Өөрчлөлт	
	2023	2024	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	1,547.9	1,746.9	199.0	12.9
Нүүрс	4,959.8	5,360.7	400.9	8.1
Төмрийн хүдэр	255.7	348.0	92.3	36.1
Цайрын баяжмал	172.6	104.0	-68.6	-39.7
Алт	396.7	473.8	77.1	19.4
Боловсруулаагүй нефть	205.9	193.3	-12.6	-6.1
Катодын зэс	57.4	66.2	8.8	15.3
Жоншны баяжмал	131.1	165.1	34.0	25.9
Адууны мах	56.0	19.9	-36.1	-64.5
Өлөн гэдэс	5.0	7.5	2.5	50.0
Үхэр, адууны боловсруулсан шир	0.6	0.4	-0.2	-33.3
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.7	0.5	-0.2	-28.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.6	0.0	-0.6	-100.0
Ямаа, ишигний боловсруулсан арьс	1.1	1.0	-0.1	-9.1
Самнасан ноолуур	41.5	33.0	-8.5	-20.5
Бохир ноолуур	178.5	198.7	20.2	11.3
Хонины самнаагүй ноос	6.5	2.7	-3.8	-58.5
Нийт экспортод эзлэх хувь	92.2	94.1		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Эрдсийн бүтээгдэхүүний экспорт:** Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 626.8 сая ам.доллар буюу 8.3 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

**1.Нүүрс:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр 46.1 сая тонн нүүрс экспортолж, 5,360.7 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 12.1сая тонноор өссөн бол экспортын орлого мөн 400.9 сая ам.доллараар буюу 8.1 хувиар өссөн байна.

Чулуун нүүрсний 99.1 хувийг БНХАУ, 0.5 хувийг Сингапур, 0.3 хувийг БНСУ руу тус тус экспортолсон байна.

**2.Зэсийн баяжмал:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 12.9 хувь буюу 199.0 сая ам.доллараар өсч, 1,746.9 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 927.6 мянган тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.1 хувь буюу 36.6 мянган тонноор өсөхөд биет хэмжээний өсөлт нөлөөлсөн байна. Зэсийн баяжмалыг 100 хувь БНХАУ руу экспортолсон байна.

**3.Алт:** 2024 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр алтны экспортын тоо хэмжээ 6.6 тоннд хүрч, 473.8 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.3 хувиар өссөн байна.

**Хүснэгт 5.** Гол нэр төрлийн эрдсийн бүтээгдэхүүний үнэ

/ам.доллар/

Барааны нэр	Жишиг үнэ 2023.07	2024 үнэ.төл	Дундаж үнэ	Жишиг үнэ 2024.07	Зөрүү жишиг үнэ
Зэс	8,358.6	9,000.0	8,996.1	9,640.7	640.7
Түүхий нүүрс	31.6-163.2	168.0	112.4	26.9-175.9	-66.6
Баяжуулсан нүүрс	44.5-174.3	204.0	120.5	41.8-174.4	-95.9
Төмрийн хүдэр	81.6-100.5	75.0	100.0	74.1-93.7	8.9
Алт /гр, төг/	214,761.0	222,762.5	276,579.1	252,783.2	30,020.6

Эх сурвалж: Сангийн яамны вэб хуудас <https://mof.gov.mn>

**Гурав. Гол нэр төрлийн импортын бүтээгдэхүүн**

Нийт импортын **22.1** хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, **77.9** хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт **1,418.2** сая ам.долларт хүрч өмнөх оны

мөн үеэс 207.0 сая ам.доллараар буюу 17.1 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт **4,992.9** сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 1,180.3 сая ам.доллар буюу 31.0 хувиар өссөн байна.

**Хүснэгт 6.** Эрдсийн болон эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт

/тн.сая ам.доллар/

Үзүүлэлт	эхний 7 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2023	2024	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	1,211.2	1,418.2	207.0	17.1	22.1
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	3,812.6	4,992.9	1,180.3	31.0	77.9
Нийт импорт	5,023.8	6,411.1	1,387.3	27.6	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.1 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 20.6 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 21.1 хувь, хүнсний бэлэн

бүтээгдэхүүн 7.2 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 8.6 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 5.3 хувийг тус тус эзэлж байна.



**Хүснэгт 7. Импортын гүйцэтгэл, барааны бүлгээр**

/сая ам.доллар/

№	Барааны нэр	эхний 7 сар		Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
		2023.07	2024.07	Дүн	Хувь	
1	Амьд мал, амьтад, мал амьтдын гаралтай бүтээгдэхүүн	81.5	80.1	-1.4	-1.7	1.2
2	Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	85.9	122.4	36.5	42.6	1.9
3	Мал амьтны болон ургамлын гаралтай тос, өөх	20.2	23.3	3.1	15.6	0.4
4	Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	361.1	462.2	101.1	28.0	7.2
5	<b>Эрдэс бүтээгдэхүүн</b>	<b>1,211.2</b>	<b>1,418.2</b>	<b>207.0</b>	<b>17.1</b>	<b>22.1</b>
6	Химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн	279.2	338.1	58.9	21.1	5.3
7	Хуванцар болон түүгээр хийсэн зүйлс; хаймар болон түүгээр хийсэн зүйлс	201.1	220.0	18.9	9.4	3.4
8	Арьс ширэн түүхий эд болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл	5.5	5.8	0.3	4.5	0.1
9	Мод, модон эдлэл	41.9	60.0	18.0	43.0	0.9
10	Цаас болон картон, тэдгээрээр хийсэн зүйлс	44.3	45.9	1.7	3.8	0.7
11	Нэхмэлийн материал болон нэхмэл эдлэл	80.1	76.7	-3.4	-4.2	1.2
12	Гутал, малгай, төрөл бүрийн бусад зүйл	19.2	21.8	2.6	13.5	0.3
13	Чулуу, гөлтгөнө, шөрмөсөн чулуу, гялтгануур болон тэдгээртэй төстэй материалаар хийсэн бүтээгдэхүүн	124.3	137.5	13.2	10.6	2.1
14	Сувд, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос	3.1	3.6	0.4	14.4	0.1
15	Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	457.0	554.4	97.3	21.3	8.6
16	<b>Машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг</b>	<b>915.9</b>	<b>1,323.7</b>	<b>407.8</b>	<b>44.5</b>	<b>20.6</b>
17	<b>Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги</b>	<b>934.0</b>	<b>1,351.0</b>	<b>417.0</b>	<b>44.6</b>	<b>21.1</b>
18	Хараа зүй, гэрэл зураг, хэмжүүр, хяналт, эмнэлгийн багаж хэрэгсэл, цаг, хөгжмийн зэмсэг эдгээрийн эд анги	72.7	78.5	5.8	7.9	1.2
19	Аж үйлдвэрийн төрөл бүрийн бараа	83.9	85.8	1.9	2.2	1.3
20	Урлагийн бүтээл, цуглуулга хийх, зориулалтын зүйлс ба эртний үнэт дурсгалын зүйлс	0.1	0.0	-0.1	-82.4	0.0
21	Бусад	1.6	2.2	0.6	35.4	0.0
	<b>ДҮН</b>	<b>5,023.8</b>	<b>6,411.1</b>	<b>1,387.3</b>	<b>27.6</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

**Импортын бүтцийг гарал үүслийн улсаар харвал:**

БНХАУ 39.9 хувь, ОХУ 25.6 хувь, Япон 9.8 хувь, БНСУ 4.2 хувь, АНУ 3.8 хувь, ХБНГУ 2.1 хувь, Энэтхэг 1.1 хувь, бусад 14.6 хувийг эзэлж байна.

6.2 хувь, цахилгаан эрчим хүч 1.8 хувь, бусад машин тоног төхөөрөж, барилгын эдлэл 5 хувийг эзэлж байна.

Импортыг барааны бүтцээр харвал: нефтийн бүтээгдэхүүн 19.5 хувь, суудлын автомашин 8.9 хувь, ачааны автомашин

## Дөрөв. Улсын төсвийн гаалийн орлого бүрдэлт

Гаалийн байгууллага нь 2024 оны эхний 7 сард нийт **3,652.6** тэрбум төгрөг төвлөрүүлэхээс **3,674.6** тэрбум төгрөг

төвлөрч гүйцэтгэл **100.6** хувьтай байна. Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал **796.8** тэрбум төгрөгөөр буюу **27.7** хувиар өссөн байна.

### Хүснэгт 8. Татварын орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.07		2024.07		Өмнөх оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь	
<b>Нийт орлого</b>	2,877.6	3,652.6	3,674.4	796.8	27.7	21.8	0.6	
<b>Гаалийн албан татвар</b>	793.2	1,037.1	976.5	183.3	23.1	-60.6	-5.8	
<b>Нэмэгдсэн өртгийн албан татвар</b>	1,712.1	2,197.9	2,151.8	439.7	25.7	-46.1	-2.1	
Архи, дарсны онцгой албан татвар	17.6	28.5	32.0	14.4	81.8	3.5	12.3	
Тамхины онцгой албан татвар	78.8	85.4	82.5	3.7	4.7	-2.9	-3.4	
Шар айрагны онцгой албан татвар	3.8	5.7	5.9	2.1	55.3	0.2	3.5	
Суудлын автомашины онцгой албан татвар	166.1	188.0	316.2	150.1	90.4	128.2	68.2	
Автобензин, дизель түлшний онцгой албан татвар	10.9	11.4	2.3	-8.6	-78.9	-9.1	-79.8	
Автобензин, дизель түлшний албан татвар	12.5	16.0	14.8	2.3	18.4	-1.2	-7.5	
Экспортын татвар	0.0	0.0	0.0	0.0	-33.3	0.0	0.0	
<b>Татварын дүн</b>	<b>2,795.0</b>	<b>3,570.0</b>	<b>3,582.0</b>	<b>787.0</b>	<b>28.2</b>	<b>12.0</b>	<b>0.3</b>	
Өөрийн орлого	64.0	74.1	85.2	21.2	33.1	11.1	15.0	
Хураамж	18.6	8.5	7.2	-11.4	-61.3	-1.3	-15.3	

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого өнгөрсөн оны мөн үеэс 796.8 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар 439.7 тэрбум төгрөг;
- Гаалийн албан татвар 183.3 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 150.1 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 14.4 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 3.7 тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар 2.3
- Шар айрагны онцгой албан татвар 2.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин автобензин, дизель түлшний онцгой албан татвар 8.6 тэрбум төгрөг, хураамжийн орлого 11.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

**Зарим төрлийн импортын бараанд ногдуулсан онцгой албан татварын орлого бүрдэлт, импортын тоо хэмжээний талаар:**

Онцгой албан татвартай суудлын автомашин: Тайлант хугацаанд онцгой албан татвартай суудлын автомашин 68,528 ширхэг импортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 30,393 ширхэг буюу 79.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс хос тэжээлт болон шингэрүүлсэн хийгээр ажилладаг суудлын автомашин 26,666 ширхэгээр, бусад суудлын автомашин 3,727 ширхэгээр тус тус өссөн.

**Хүснэгт 9.** Онцгой албан татвартай суудлын автомашины импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл	Импортын тоо хэмжээ /ширхэг/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
	2023.07	2024.07	Зөрүү	Хувь	2023.07	2024.07	Зөрүү	Хувь
Хос тэжээлт	29,256.0	55,922.0	26,666.0	91.1	215.0	438.0	223.0	103.7
Бусад	8,879.0	12,606.0	3,727.0	42.0	148.0	194.0	46.0	31.1
<b>Нийт</b>	<b>38,135.0</b>	<b>68,528.0</b>	<b>30,393.0</b>	<b>79.7</b>	<b>363.0</b>	<b>632.0</b>	<b>269.0</b>	<b>74.1</b>

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Ногдуулсан татварын хэмжээг авч үзвэл:

- Автобензин, дизелийн хөдөлгүүрээр ажилладаг автомашин /цаашид “бусад” гэх/ онцгой албан татвартай автомашин- **193.6** тэрбум төгрөг,
- Хос тэжээлт болон, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашин-**438.0** тэрбум төгрөг тус тус ногдуулжээ.

Автобензин, дизелийн түлш: Монгол улс шатахууны хэрэгцээгээ 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2024 оны эхний 7 сард **1,443.1** мян.тн автобензин, дизелийн түлшний бүтээгдэхүүн импортолсон байна.

**Хүснэгт 10.** Автобензин, дизелийн түлшний импортын тоо хэмжээ, ногдуулсан татвар

Төрөл		Импортын тоо хэмжээ /мян.тонн/				Ногдуулсан татвар /тэрбум төгрөг/			
		2023.07	2024.07	Зөрүү	Хувь	2023.07	2024.07	Зөрүү	Хувь
Нийт		1,215.4	1,443.1	227.7	18.7	430.7	518.0	87.3	20.3
Автобензин	A-80	14.5	3.5	-11.0	-75.9	5.4	1.4	-4.0	-74.1
	A-92	403.0	489.0	86.0	21.3	115.6	132.0	16.4	14.2
	A-95 болон түүнээс дээш	10.9	12.3	1.4	12.8	2.3	8.9	6.6	287.0
Дизель түлш		786.9	938.2	151.3	19.2	307.4	375.7	68.3	22.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах” тухай 244 дүгээр тогтоолоор дизелийн түлшний Онцгой албан татварыг 2025-01-01 хүртэл “0” хувь хэмжээгээр тогтоосон. Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолд өөрчлөлт оруулах” тухай 496 дугаар тогтоолын дагуу 2023-07-01 хүртэлх хугацааг сунгасан. Ингэснээр 2024 оны эхний 7 сарын байдлаар нийт 938.2 мян.тн дизель түлшинд ногдуулах 245.9 тэрбум төгрөгийн онцгой албан татварыг хөнгөлсөн.

Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох тухай” 85 дугаар тогтоолоор импортоор оруулж ирсэн 92 октантай автобензиний гаалийн тарифыг “0” хувиар тогтоосон. Ингэснээр 2024 оны эхний 07 сарын гүйцэтгэлээр нийт 489.0 мян.тн бүхий бараанд 59.1 тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн.



## Тав. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хойшлуулалт

2024 оны эхний 7 сард нийт импортод татвартай импорт 93.8 хувь, татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээрээ 6.2 хувийг тус тус эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 4,083.6 тэрбум төгрөгөөр буюу 25.1 хувиар өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт

277.7 тэрбум төгрөгөөр буюу 26.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 11. Импортын бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023.07	2024.07	Өөрчлөлт (+,-)	Хувиар	Эзлэх
Татвартай импорт	16,263.3	20,346.9	4,083.6	25.1	93.8
Татвараас чөлөөлөгдсөн импорт	1,067.0	1,344.6	277.6	26.0	6.2
Нийт импорт	17,330.2	21,691.5	4,361.3	25.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын 1,344.6 тэрбум төгрөгийн бараанд 2024 оны эхний 7 сард ногдуулвал зохих **197.2** тэрбум төгрөгийн татварыг холбогдох хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдсөн байна.

### Хүснэгт 12. Татварын чөлөөлөлтийн бүтэц

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Үнийн дүн	Дүн
Бусад	262.6	36.5
Гадаадын хөрөнгө оруулалт: УБТЗ	360.6	55.9
Засгийн газрын болон Олон улсын байгууллагын тусламж	189.6	29.6
Засгийн газрын болон олон улсын байгууллагын зээл	203.3	31.1
Иргэний агаарын зорчигч тээврийн хөлөг онгоц, түүний сэлбэг	117.5	18.9
Сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг	14.3	1.9
ХАА-н зориулалттай тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис	143.9	15.1
Хийн түлш тэдгээрийн тоног төхөөрөмж	53.0	8.2
Нийт дүн:	1,344.6	197.2

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Загийн газрын 2024 оны 188-р тогтоолоор батлагдсан Цементийн албан татварын хувь хэмжээг 20 байсныг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 10 дугаар сарын 01-ныг хүртэл хугацаанд 5 хувь болгон бууруулсан тогтоолыг тарифын санд оруулж хэрэгжилтэд хяналт тавьсан. Нийт 4.1 сая ам.долларын дүн бүхий 64 сая.тн, **4.1** тэрбум төгрөгийн татварыг хөнгөлсөн байна.

2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Засгийн газрын 180 дугаар тогтоолыг тус тус үндэслэн импортын малын тэжээл болон гурил бүхий 946.3 сая төгрөгийн бараанд ногдуулвал зохих гаалийн албан татварыг чөлөөлжээ.

## Татварын хойшлуулалт

Засгийн газрын 2022 оны 335 дугаар тогтоолыг хэрэгжүүлж Шивээхүрэн боомтын чингэлэг тээврийн терминалын төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан импортоор оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Эрчим хүчний сайд, “Шивээхүрэн терминал” ХХК, “Нарийн сухайт эрчим” ХХК-ийн хооронд 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр 25/Г-27/2033/012-23/А/2023-13/ тоот гэрээ байгуулагдаж, “Нарийн сухайт эрчим” ХХК гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийг 2023 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн импортолж, **1.8** тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

Засгийн газрын 2015 оны 190 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Цагаан суваргын зэс, молибдений баяжуулах үйлдвэр төслийн бүтээн байгуулалтын ажилд зориулан оруулж ирэх техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Уул уурхайн сайд, “Монголын алт” ХХК, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ийн хооронд 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдөр 41,20,195-2323/0012-5123 тоот гэрээг байгуулж, “Эрдэнэс цагаан суврага” ХХК-ийн гэрээний хавсралт жагсаалтад заагдсан тоног төхөөрөмжийн үнийн дүнд 2023 оны 5 дугаар сарын 22-ноос эхлэн ногдуулсан **29.8** тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Говь-Алтай аймгийн Тайшир суманд байрлах “Дөрвөлжин шохойн чулууны ордын цемент, шохойн үйлдвэр”-ийн бүтээн байгуулалтад зориулан импортоор оруулж ирсэн техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 2 жилийн хугацаатай хэсэгчлэн төлүүлэх тухай Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайд, “Цэнгазар” ХХК-ийн хооронд 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр 2024/73/47 тоот гэрээг байгуулж, 489.9 мянган ам доллар бүхий бараанд 2024 оны 3 дугаар сарын 31-нээс эхлэн **4.1** тэрбум төгрөгийн татварыг хойшлуулан гаалийн бүрдүүлэлт хийсэн байна.

## Тээвэр, ложистик

БНХАУ-ын төмөр замын байгууллага Тяньжин боомтоос 2024.05.01-ний өдрөөс Монгол Улс руу чиглэсэн чингэлгийн тоог өдөрт 2 цуваагаар чингэлэгүүдийг татдаг байснаа 1 болгосноор 40 орчим хувь болгож бууруулсан. Тяньжин боомтод хуримтлагдан 6900 гаруй чингэлэгийг татах ажил 7 дугаар сард эрчимжсэнээр дундаж галт тэрэгний тоо 7.5 болж нэмэгдсэн нь Улсын төсвийн орлого бүрдүүлэх шалтгаан болжээ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС